



ОРХОН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(зарын үсэг)

Тэмдэг

(огноо)

Төлөвлөгөөг баталсан:

Төсвийн Шүүд-захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА...../М.ОТГОНБАЯР/

(албан тушаал)

Тэмдэг

(огноо)



Засгийн газрын хэрэг эрхлэх газрын  
100 тоот тушаалын 7 дугаар хавсралт

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Стратеги төлөвлөгөө болон байгаа бодлогын бичиг, тогтоомж	Үндэслэж бусад баримт хууль	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛГО: БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТЛОЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАМ ХАНГАМЖИЙГ САИЖРУУЛАХ</b>								
<b>Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</b>								
1.1	Тоон гарын үсэг олгох ажлыг байгуулах	зохион	Улсын төсөв	Монгол улсын иргэнд олгох үндэсний тоон гарын үсгийг нэвтрүүлсэн байх	Эрх зүйн орчин бүрдсэн байх тоон гарын үсгийг олгох ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах	Цахим гадаад паспортад бичих тоон гарын үсгийг нэвтрүүлсэн байна.	Монгол Улсын Их Хурлаар батлагдсан "Цахим гарын үсгийн тухай хууль"-ийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 01 ний өдрөөс иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулаа.	100%
							Үүнээс: 11288 нь иргэний үнэмлэхний чипэнд, 2517 нь Мобайл апп-аар олгосон байна. Хүйсийн хувьд: 6882 нь эрэгтэй, 6923 эмэгтэй. Насны бүлгээр авч үзвэл:	

						16-24 насны 642, 25-44 насны 7660, 45-60 насны 4916, 60-аас дээш насны 587 иргэнд тус тус олгосон.	
						Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх төслийн багийг 7 хүний бүрэлдэхүүнтэй томилж 2022.01.19-2022.05.27 ны өдрийг хуртэлх хугацаанд 12 удаагийн сургалтанд, дэмжих багийнхан буюу нийт албан хаагчдыг 3 удаагийн сургалтанд тус тус хамруулгаа. Үйл ажиглагаандаа “Чанарын менежментийн тогтолцоо” ISO: 9001 : 2015 менежментийн тогтолцоог стандартын шаардлагын дагуу нэвтрүүлснийг баталгаажуулан 3 жилийн хугацаатай гэрчилгээгээ авлаа.	
1.2	Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	Албан хаагчдыг сургалтад хамруулж, бэлтгэл ажлыг хангасан байна.	-	Албан хаагчдыг чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр сургалтад хамруулсан байна.			100 %
<b>Зорилт 2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.</b>							
2.1	E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталгаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэх бүрт иргэдэд сурталчилгах ажлыг зохион	Сурталчилсан тоо	-	Цахим үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна.	Хэлтсийн Фэйсбүүк хуудас болох( <a href="https://www.facebook.com/orbitfel">https://www.facebook.com/orbitfel</a> ), Цахим хуудас ( <a href="https://orkhon.bitfel.gov.mn/">https://orkhon.bitfel.gov.mn/</a> ) –аар Цахим бүртгэлтэй холбоотой 28		90%

	Байгуулах				<p>Мэдээ мэдээллийг тухай бүр түгээн сурталчилж, олон нийтэд 6 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг, Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болох ETV ТВ болон Номин ТВ, Эрдэнэт Инфо сайт зэрэгт нийт 6 удаагийн ярилцлага өгсөн төдийгүй тус хэлтсээр үйлчилгээ авч буй иргэдэд цахим портал үйлчилгээг давхардсан тоогоор 33047 иргэнд сурталчилсан байна.</p>	
2.2	<p>Улсын бүртгэлийн асуудлаар төрийн болон бусад байгууллагатай харилцан мэдээлэл солилцох, дундын мэдээллийн сан ашиглах</p>	<p>ГХБХБГ-ын дундын сангаас олгосон Э-дугаарын тоо</p>	<p>Төрөлтийн мэдээллийг дундын мэдээллийн сангаар дамжуулан авч ГХБХБГ ын Э-3546 дугаар цахимаар олгосон.</p>	<p>ГХБХБГ тай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна</p>	<p>ГХБХБГ-ын дундын мэдээллийн санд нийт 1120 дугаар шинээр олгосон байна. Үнд. Баян-Өндөр суманд Э-дугаар 765, А дугаар- 6, Жаргалант суманд Э-дугаар 361, Жаргалант А-дугаар 1 тус тус олгогдсон байна. БОЭТ нь дундын мэдээллийн сангаас шинээр төрсөн 1928 хүүхдэд регистрийн дугаар олгосон байна.</p>	100%

2.3	Улсын Хууль холбогдох дагуу хөтлөх бүртгэлийг тогтоомж журмын	Бүртгэлийн тоо	2021 онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 13673, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 1702, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 13188 бүртгэл хийгдсэн.	Бүртгэлийн үйлчилгээ иргэдэд хөнгөн шуурхай хүрч бүртгэл үнэн зөв байх.	Жилийн эцсийн байдлаар иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 14459 бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 1083 бүртгэл, мөн E-Mongolia цахим апликейшнээр оноосон нэрийн баталгаажилт хийх хүсэлт -832, цахим гэрчилгээ авах 20 хүсэлт, нэмэлт өөрчлөлт оруулах -5 хүсэлтийг тус тус хүлээн авч баталгаажуулан бүртгэлийг хууль журмын дагуу цаг хугацаанд нь шуурхай хийлээ. Мөн эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр нийт 17505 бүртгэл хийсэнээс: газраас бусад үл хөдлөх эд хөрөнгий бүртгэл 10699, газрын бүртгэл 6806 хийгдсэн байна.	100%
-----	---	----------------	---	---	---	------

2.4	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх	-	2021 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 7478, хууль хяналтын байгууллагад 3226 лавлагаа мэдээллийг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн сангаас мэдээллийн иргэнд 127, хууль хяналтын байгууллагад 50, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 344 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа мэдээллийг хууль хяналтын байгууллагад 1416 лавлагааг албан бичгээр тус тус олгосон.	Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг заасан хуульд олгосон хугацаанд байна.	Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 143 лавлагааг иргэнд, 135 лавлагааг хууль хяналтын байгууллагад, иргэний бүртгэлийн чиглэлээр хууль хяналтын байгууллагад 2731, иргэнд 7867 лавлагааг, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр иргэнд 292 хууль хяналтын байгууллагад 861 лавлагаа мэдээллийг тус тус олгоноос эрх сэргээсэн 120, эрх түдгэлзүүлсэн 54, лавлагаа хуулбар 189, барьцаа чөлөөлсөн 164, бусад лавлагаа мэдээлэл 234 -г олгосон байна.	100 %
2.5	Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах,	Цахимжуулсан иргэний бүртгэлийн эх нотлох баримтын тоо	Иргэний улсын бүртгэлийн онлайн, оффлайн системээр иргэний улсын бүртгэл хөтөлсөн эх нотлох баримт бичиг цахимжуулах, тоног төхөөрөмжөөр хангагдсан.	Бүрдүүлбэрийг тухай бүр нь цахимжуулсан байна.	01 дүгээр сарын 10 ны өдрөөс эхлэн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт болох бүрдүүлбэр, ИУБ мяагтуудыг цахимжуулах ажлыг эхэлсэн. Нийт 14559 бүртгэлийн 35850 хуудас материал цахимжуулаад байна.	100%

**Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.**

<p>3.1 Хяналт төлөвлөгөө хэрэгжилтийг хангах</p>	<p>-</p>	<p>Хяналт шалгалтын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах</p>	<p>2021 онд төлөвлөгөөт болон гэнэтийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 76 дүгнэлт гаргасан. ИУБ ийн чиглэлээр -3188, ХЭУБ ийн чиглэлээр -127, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр -658 бүртгэлд хяналт шалгалт хийж 45 зөрчил илрүүлж 28 зөрчлийг арилгуулсан.</p>	<p>Төлөвлөгөөний бүрэн хэрэгжилтийг хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна.</p>	<p>Төлөвлөгөөний дагуу Иргэний бүртгэлийн чиглэлээр 5137 бүртгэлд, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр, 410 бүртгэлд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 3807 бүртгэлд, мөн архивын чиглэлээр 12281 бүртгэлд тус тус хяналт шалгалт хийлээ. Шалгалтын явцад 37 бүртгэлийн зөрчил илрүүлснээс зөрчлийн албан шаардлага өгч тухай бүр нь арилгуулах арга хэмжээ авч ажилласан бөгөөд 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс бүртгэлийн зөрчил 17.7 хувиар буурсан байна.</p>	<p>100%</p>
--	----------	--	--	--	---	-------------



3.2	Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг шийдвэрлэлтийн сан бүрдүүлэх,	Хэрэг маргаанд дүн шинжилгээ хийх	Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг гаргасан.	- Баяжилтыг тухай бүр нь хийсэн байна. - Хэрэг маргаан шийдвэрлэлтийн нэгдсэн сан бүрдсэн байна.	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр маргаантай 8 хэрэг шүүхийн байгууллагад байна. Хэрэг маргааны сан бүрдүүлэн холбогдох мэдээлэл судалгааг бүртгэхийн зэрэгцээ УБЕГ- т судалгааг хүргүүлсэн. Маргаан бүхий бүртгэлд дүн шинжилгээ хийхэд иргэд эд хөрөнгийн бүртгэлийн талгаарх мэдлэг бага, мөн бүртгэгчийн хайхрамжгүй алдаа байна.	100%
3.3	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо	2021 онд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 156 иргэн .хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж торгох шийтгэл ногдуулан 40100000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.	Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөрчил үйлдсэн 226 иргэн, 2 хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч нийт 6080000 төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэн, хуулийн хугацаанд прокурорт хянуулснаар хугацаа	100%



						хоцруулсан зөрчилгүй, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.	
3.4	Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тоо	—	Хууль шүүхийн хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон байна.	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр шүүхийн 8 хэрэг маргаанд Эд хөрөнгийн ахлах бүртгэгч хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцлоо.	100%	
3.5	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавин ажиллах	-Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо; -Хугацаандаа байршуулсан эсэх;	2021 оны 11 сарын байдлаар шилэн дансны цахим сайтad 136 төрлийн мэдээлэл оруулахаас 136 мэдээллийг хугацаа хоцролгүй, үнэн зөв байршуулсан.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	2022 оны эхний 11 сарын байдлаар шилэн дансны цахим сайтad 136 төрлийн мэдээлэл оруулахаас 136 мэдээллийг хугацаа хоцролгүй, үнэн зөв, бүрэн гүйцэд байршуулсан.	100%	
3.6	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах	Батла гдсан төсөв -Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх; -Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй ажилласан эсэх;	2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч зөрчлийг 33,3 хувиар бууруулсан. 2021 онд 423,7 сая төгрөгийн урсгал төсвөөс 399,9 сая төгрөгийг зарцуулсан.	Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хуацаанд аудитын хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна.	2021 оны Санхүүгийн тайлангийн аудитаар ЗӨРЧИЛГҮЙ санал дүгнэлт авсан бөгөөд 3 зөвлөмж, 1 албан шаардлагын харилт хуулийн хугацаанд нь холбогдох байгуул лагуудад хүргүүлэн ажилласан. 2022 онд 413,7 сая төгрөгийн урсгал төсвөөс 398,2 сая төгрөгийг зарцуулсан.	100%	

	<p>Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах</p>	<p>-</p>	<p>2021 онд УБЕГ аас 54,9 сая төгрөгийн тусгай зориулалтын бараа материал, бусад байгууллагаас 5,8 сая төгрөгийн бараа материал тус тус шилжүүлэн авч материалын тасалдал үүсгээгүй.</p>	<p>Бараа материал хангалтыг цаг хугацаанд нь татан авах</p>	<p>УБЕГ-с 12,3 сая төгрөгийн тусгай зориулалтын бараа материал, бусад байгууллагаас 10,9 сая төгрөгийн бараа материал тус тус худалдан авч материалын тасалдал үүсээгүй.</p>	<p>100%</p>
<p>3.7</p>	<p>Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиглах</p>	<p>-Үйлчилгээний стандарт хэрэгжилтийн %</p>	<p>2021 онд ямар нэг зөрчилгүй ажигласан.</p>	<p>Зөрчил дутагдалгүй ажигласан байх</p>	<p>Үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх зорилгоор өөрсдийн боломжинд тулгуурлан бүртгэлийн лого бүхий нэг өнгийн цамц өдөр тутам өмсдөг төдийгүй ажлын цаг баримталж хэвшсэн. Бүртгэлийн алдаа, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдыг даргын зөвлөлөөр хэлэлцэж арга хэмжээний саналыг Тамгын Газрын даргад хүргүүлсэн. 7 хоног бүрийн хэлтсийн даргын шуурхай зөвлөгөөн дээр ёс зүй, хөдөлмөрийн дотоод журам баримтлах иргэдэд хөнгөн шуурхай хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэхийг байнга зөвлөж сануулж ирсэн нь протоколд тусгагдсан болно.</p>	<p>100%</p>
<p>3.8</p>	<p>Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиглах</p>	<p>-Үйлчилгээний стандарт хэрэгжилтийн %</p>	<p>2021 онд ямар нэг зөрчилгүй ажигласан.</p>	<p>Зөрчил дутагдалгүй ажигласан байх</p>	<p>Үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх зорилгоор өөрсдийн боломжинд тулгуурлан бүртгэлийн лого бүхий нэг өнгийн цамц өдөр тутам өмсдөг төдийгүй ажлын цаг баримталж хэвшсэн. Бүртгэлийн алдаа, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдыг даргын зөвлөлөөр хэлэлцэж арга хэмжээний саналыг Тамгын Газрын даргад хүргүүлсэн. 7 хоног бүрийн хэлтсийн даргын шуурхай зөвлөгөөн дээр ёс зүй, хөдөлмөрийн дотоод журам баримтлах иргэдэд хөнгөн шуурхай хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэхийг байнга зөвлөж сануулж ирсэн нь протоколд тусгагдсан болно.</p>	<p>100%</p>

3.9	Эд хөрөнгийн архивын зориулалтын эвдэрсэн нягтаршуулсан шүүгээг шинэчилж сайжруулах		АЗДТГ-т хусалт төсөл гаргах хэрэгжүүлэх	52 нягтаршуулсан шүүгээ ашиглаж байна.6 шүүгээ шаардлага хангахгүй болсон.	Төслөөр эд хөрөнгийн архивын шүүгээг шинэчилсэн байна.	Архивын нягтруулсан шүүгээ авах 20 сая төгрөгийг АЗД аас шийдвэрлэсэн бөгөөд нийлүүлэх компани нь гэрээ байгуулсан.Хил гаалийн нөхцөлөөс шалтгаалан хүлээгдэж байна.	95%
3.10	Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах		-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	Архивын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хангагдсан байна.	Эд хөрөнгийн архивч гэмтэж муудсан 120 хувийн хэргийг сэлбэж, хавтаслан салсан болон гэмтсэн 500 дугаарыг сольж засварлалаа.Төлөвлөсөн ажлаа бүрэн хийж гүйцэтгэлээ.	100%
3.11	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн тайлан мэдээ хүргүүлэх		-Хүргүүлсэн тайлан мэдээний тоо	Хуулиар тогтоосон шаардлага хангасан этгээдийг тайлан мэдээгээр бүрэн хангаж ажилласан.	Шаардлагатай бүртгэлийн мэдээ тайланг цаг хугацаанд нь хүргэх	Ерөнхий газрын нэгдсэн архивт сар бүрийн 25 нд 3 бүртгэлийн мэдээг тус тус 11 удаа гаргаж хүргүүлжээ. Холбогдох албан тушаалтан байгууллагад сар бүр мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргаж өгсөн.Тайлан мэдээг цаг хугацаанд иж бүрэн гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилласан.	100%

**Зорилт 5.** Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.

	<p>УБЕГ ын даргын баталсан “Нийгмийн баталгаа хангах” хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын нийгмийн асуудлыг шат дараатай тавьж шийдвэрлүүлэх</p>		<p>Хөтөлбөр хэрэгжилтийн хувь</p>	<p>2021 онд ЭХЭБ ийн бүртгэгч Б.Батэрдэнэд 2 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.</p>	<p>Хөтөлбөр хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажиллах</p>	<p>Өөрсдийн болгож санхүүгийн нөөцөд тулгуурлан шинэ төрсөн-2 хүүхэд, шинэ гэр бүл болсон-1, гэрийн хороололд амьдарч буй 2 албан хаагчид тулээ нүүрсний хөнгөлөлт үзүүлэхэд нийт 1,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Эрүүл мэндийг дэмжих төвтэй хамтарч бүх албан хаагчдыг/29/эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзэлт хамрууллаа. Албан хаагчдын дунд явган аялал-1 удаа зохион байгуулж, ажлын байран дахь дасгал тогтмол хийж хэвшлээ. Мөн спортын арга хэмжээ бүртгэлийн ой угтан явууллаа.</p>	<p>100%</p>
<p>5.2</p>	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө</p> <p>Боловсруулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах</p>		<p>Төлөвлөгөөний биелэлт %</p>	<p>2021 онд төлөвлөгөөний биелэлт 100 %</p>	<p>Төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлсэн байх</p>	<p>УБЕГ ын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 25 арга хэмжээ төлөвлөж төлөвлөгөө 100 хувь биелэгдлээ.</p>	<p>100%</p>

5.3	“Хэлтсийн хаагчдын төлөвлөгөө болговсруулж, хэрэгжилтийг ажиглах”	албан сургалтын 2022”-ыг ханган	-	-Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх; -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2021 онд сургалтын төлөвлөгөө болговсруулж, 18 төрийн захиргааны албан хаагчид өөрт ногдсон сэдвээр дотооддоо сургалт зохион байгуулсан.	Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу нийт албан хаагчдад дараахь сургалтуудыг үр дүнтэй зохион байгууллаа. Үүнд: “Өсвөр насны хүүхэдтэй харилцах арга зүй” сэтгэл зүйч Мөнхтуулын сургалт, “ЕО-Бидний амьдралд” УА- н захирал доктор Д.Сүрэнчимэг, ББ сангийн зөвлөх Б.Төгөлдөрийн “Аз жаргалтай ажиллах нууц” сургалт, “Гэр бүлийн үнэ цэнэ” Алтанцоож багш Хүний эрхийн салбар комиссын мэргэжилтэн Батзаяа, цагдаагийн мэргэжилтэн Ц.Ганчимэг нарын “Жэндэр ба хүний эрх” Гэр бүлийн хүчирхийлэл” сургалт, Илтгэх урлагийн багш Хүрэлбаатарын “Цагийн менежмент” сургалт, БОЭТ ийн мэргэжилтэн Болормаагийн “Эрүүл зохистой идээ ундаа” зэрэг сургалтуудыг тус тус амжилттай зохион байгууллаа.	100%
-----	---	---------------------------------	---	---	--	---	--	------

<p>5.4</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах</p>	<p>-</p>	<p>-Сургалтад хамрагдсан хаагчийн тоо; -Заавартай танилцсан албан хаагчийн тоо;</p>	<p>-2021 онд ЭД хөрөнгийн-6, иргэний-9, хуулийн этгээдийн -1 бүртгэгч нар тус тус 2 удаа сургалтад хамрагдсан.</p>	<p>Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.</p>	<p>Хүний нөөцийн системийн сургалтуудад тухай бүр хамрагдан үнэлгээ, сорил шалгалтуудыг өгч ажиглалаа. 2022 онд УБЕГ болон ТАЗ-аас зохион байгуулсан сургалтуудаас Нийт-29 албан хаагчдад зориулсан- 26 сургалт, Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой- 7 сургалт, Иргэний улсын бүртгэлтэй холбоотой- 7 сургалт, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой- 3 сургалт, Архивч, бичиг хэрэг, нягтлан бодогчид зориулсан-3 сургалт, Хяналтын улсын байцаагчтай холбоотой- 4 сургалт, Удирдах албан тушаалтны- сургалт, мэдээлэл технологийн ажилтны- 8 сургалтад холбогдох албан тушаалтнуудыг бүрэн хамрууллаа.</p>	<p>90%</p>
---	----------	---	--	---	--	------------



					Давхардсан тоогоор 59 удаагийн сургалтанд нийт 29 албан хаагч 100% хамрагдсан.	
5.5	Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх,хяналт тавьж ажиллах	-шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо, %	2021 онд 16 өргөдөл ирснийг 100% шийдвэрлэж иргэнд хариуг хүргүүлсэн.	Хуулийн хугацаанд өргөдөл гомдлыг шийдвэрлэх	Тайлангийн хугацаанд иргэдээс нийт 21 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд 100 % шийдвэрлэн хариуг иргэдээс олголоо. Ирээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг ангилан авч үзвэл:Хүсэлт- 13,гомдол - 5,талархал-2,санал-1 ирсэн байна.	100%

**Зорилт 6.** “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Эхлэх , дуусах огноо
<b>“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль, тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших , тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд</b>				
6.1	Монгол бичгийн мэдлэг чадвараа дээшлүүлэхээр бие даан суралцах, сургалтад хамрагдах,англи хэлний түвшинг сайжруулах	Монгол бичгийн чадвартай болох -англи хэлний зохих түвшний мэдлэгтэй болох	Монгол хэл бичгийн анхан шатны мэдлэгтэй болсон .Англи хэлний мэдлэгийн түвшингээ сайжруулах зорилгоор дунд шатны онлайн сургалтанд хамрагдаж дүрмийн мэдлэгтэй болсон.	100 %



6.2	<p>УБЕГ аас болон аймаг орон нутгаас зохион байгуулсан онлайн болон танхимын сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлэх, бүртгэлтэй холбоотой хууль журмыг судлах, Ахлах түшмэлийн мэргэшсэн сургалтад хамрагдах</p>	<p>Хууль тогтоомжийн мэдлэг дээшилсэн байх</p>	<p>2022.05.09 ны өдөр Ахлах түшмэлийн сургалтын 9 багц хичээлийг судалж, шалгалт өгч №д 2992 дугаартай сертификат авлаа. УБЕГ аас зохион байгуулсан 23 багц хичээл, Төрийн албанаас зохион байгуулсан 7 хоног бүрийн 7: 4 :10 сургалтанд тогтмол хамрагдлаа. Бие дааж судлах 9 хичээлийг үзэж төстийн шалгалтыг өглөө.</p>	100%
-----	--	--	--	------